



Соёлын биет бус өв



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

ichcap

International Information and Networking Centre
for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region
under the auspices of UNESCO



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Mongolian
National Commission
for UNESCO



Соёлын биет бус өв ба жендэр



© Umumura Yutaka



© Saïd Azadi



© Fumiko Ohinata

Translator: **Machlay Tuul**
Proofreader: **Urtnasan Norov**

Жендэрийн шинж төрхүүдийг бүтээхүй

Нийгэм, хамт олон болон бүлгүүд доторх жендэртэй (эр эм хүмүүстэй) хамааралтай үнэт зүйлс, хэм хэмжээ ба дэг жаяг нь харилцан адилгүй олон янз байдаг. Соёлын биет бус өвийн бүх илэрхийллүүд нь тухайн хамт олны доторх хүйсийн бүлгүүдийн хоорондын болон бүлэг доторх харилцааны талаарх мэдлэг, хэм хэмжээг тээж, өвлөн уламжилж байдаг. Энэ утгаараа соёлын биет бус өв нь хүйсийн үүрэг, шинж төрхүүдийг тодорхойлох болон түүнийг өвлөн уламжлуулахад бусдаас илүү нөлөө бүхий утга учиртай юм. Иймээс соёлын биет бус өв нь жендэрийн шинж төрхийг төлөвшүүлэх явцтай салшгүй холбоотой.

Ихэнх хамт олны уламжлалт хоолны соёлын хүрээнд эмэгтэйчүүд нэр хүндтэй үүрэг хүлээдэг. Энэхүү ажил үйлийг хийхэд ээж, охидын хоорондын харилцаа чухал байдаг: ээжүүд ажлаа хийхэд нь охид туслахын зэрэгцээ харж, ажиглаж, хамт суралцаж байдаг: Охид ийнхүү ээжийгээ даган эмэгтэй хүний өвөрмөц тусгай ажил үүргийг аажмаар олон дахин хийснээр тэдний эмэгтэй хүн болох шинж төрхийн нэгэн хэсгийг бүрэлдүүлдэг.



© UNESCO / Danson Siminyu



© 2008 by Ministry of Culture - Photograph: Iris Biskupic Basic



© 2008 by Ministry of Culture - Photograph: Iris Biskupic Basic

Тэмээ нь Оманы Бэдуин хамт олны уламжлалт арга хэмжээ болон баяр наадмуудын салшгүй нэг хэсэг юм. Тэмээ өсгөн үржүүлэхтэй холбоотой гар урлалын тухайд гэвэл эрчүүд болон эмэгтэйчүүд шаардлагатай тоног хэрэгсэл хийхэд тус тусын үүрэгтэй. Эмэгтэйчүүд гол төлөв нэхмэл бүтээгдэхүүн хийдэг бол эрчүүд нь модны сийлбэрчид, дархчууд байдаг. Үүнтэй ижил төстэй хөдөлмөрийн хуваарилалтыг Хорватын Хрватско Загорже тосгоны хүүхдийн модон тоглоомын уламжлалт үйлдвэрлэлээс харж болно. Тэд олон үеийн турш гэр бүл дотроо өвлөн уламжлагдаж ирсэн техникийг ашигладаг. Эрчүүд нь зөөлөн уд мод, хар мод, эвэрлэг мод болон агч модыг олж сонгон аваад дараа нь түүнийгээ уламжлалт хөдөлмөрийн багаж ашиглан хатааж, засаж, тайрч, сийлбэрлэн тоглоом хийдэг. Эмэгтэйчүүд дараа нь түүнийгээ санаанаасаа зохиосон цэцгэн болон геометрийн хээ угалзаар уран сэтгээж, зурж чимэглэдэг.

Соёлын биет бус өвийн зарим тусгай зүйлүүдийг үзэж харах, тэдгээрийг үйлдэхэд эрэгтэй эсвэл эмэгтэй хүмүүс байхыг эрхэмлэдэг ёс бас бий. Жишээлбэл, уламжлалт гар урлал нь гол төлөв туслах болон эрэгтэй юм уу эмэгтэй хүн хийхийг шаарддаг хөдөлмөрийн хуваарилалтад суурилдаг.

Нөгөө талаас зан заншил, баяр ёслолын арга хэмжээнүүд болон тоглоон үзүүлэх урлаг нь тухайн хамт олны доторх жендэрийн үүрэг, адил тэгш бус байдал зэрэг шийдвэрлэх асуудал болоод нийгмийн элдэв хоцрогдсон зуршил, зан үйлийг ил гаргаж тавих нь бас байна. Тухайлбал нийтийн уламжлалт баяр наадмын болон тоглолт үзүүлбэрүүдийн үеэр эрчүүд эмэгтэйчүүд хүйсийн дүрээ сольж тоглох, заримдаа энэ нь бүр хэвшил болж өөрчлөгдөх нь ч бий. Иймэрхүү байдлаар бүлэг хамт олноуд хүйсийн гүйцэтгэх үүргийн талаарх ойлголтыг сайжруулах, тэдгээрийг амьдралд илэрхийлэхэд тус дэм үзүүлж зарим тохиолдолд жендэрийн хэм хэмжээ зуршлыг шүүн хэлэлцэх орон зайг өөрсдөө бий болгож байдаг.

Жендэрийн үүрэг болон харилцаа хувьсан өөрчлөгдөх нь

Хүмүүс жендэрийн оногдсон үүргийг ерөнхийдөө бага наснаасаа даган дуурайн танин мэдэж суралцсан байдаг. Гэвч хүйсийн үүрэг нь өөрчлөгддөггүй байнгын зүйл биш юм. Соёлын биет бус өвийн нэгэн адил хүйсийн үүрэг нь үргэлж өөрчлөгдөж шинэ нөхцөл байдалд идээшин дасаж байдаг. Хамт олноуд цаг үргэлж өөрсдийн хүйсийн үүрэг болоод хэм хэмжээ, дэг ёсыг шүүн ярилцаж ‘хэлэлцдэг’ бөгөөд өнгөрсөн хугацаанд нэг хүйсийн бүлгийн онцгой мэдэлд байсан олон тооны хүйсийн онцлог шинжтэй уламжлалууд нь бусад хамт олонд нээлттэй болж өөр хүйсийн бүлгийн хүмүүс оролцож эхэлдэг байна.

Соёлын биет бус өв нь хүйстэй холбоотой үнэт зүйлс, хэм хэмжээ, дэг ёсыг бүтээх хийгээд түгээн дэлгэрүүлэх, түүнчлэн тэдгээрийг үүсгэн бий болгох, өөрчлөн хувиргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ёс заншлыг өөрчлөх бодол сэдэл нь зарим аюул бэрхшээлээс гарах гэсэн оролдогоос үүдэлтэй, прагматик шинжтэй байж болох юм. Энэ нь бас эрэгтэй эмэгтэй хүмүүст адил тэгш боломж олгох гэсэн зарчмын бодлоготой



© Umumura Yutaka

Вьетнамын Чау ван бөөгийн тайлгын дуунд хүйсийн үүрэг нь эмэгтэйчүүд уламжлалт 'эрэгтэй' дүр, хувцас ба үйл хөдлөлийг авч тоглох юм уу эсвэл эсрэгээр эрчүүд нь эмэгтэйчүүдийн үүргийг гүйцэтгэх байдлаар солигдож байдаг. Үүнтэй төстэйгөөр Японы уламжлалт Кабуки жүжигт эрэгтэй нь эмэгтэйн дүрд зориудаар орлон тоглож үүрэг нь өөрчлөгдөх агаад түүнийг нь 'оннагата' хэмээн нэрлэдэг. Өөр гол хоёр дүрийн төрлүүд нь 'арагато' (догшин ширүүн) ба 'вагото' (зөөлөн хэв маяг) юм. Эдгээр дүрүүдийн онцлог шинж гэвэл хүйсийн үүргийн тодорхой бус хоёрдмол байдал ба хүйсийн үүргийг өөрчлөн солих боломж бөгөөд энэ нь эр эм хүйсийн хос үүрэг бүхий системийн тухай хэлэлцэхэд хүргэж байгаа болно. Кабукигийн жүжгүүд нь зүрх сэтгэлийн харилцаан дээр тулгуурласан түүхэн үйл явдлууд болон ёс суртахууны зөрчлүүдийн тухай өгүүлдэг. Өдгөө Кабуки нь Японы жүжгийн хамгийн алдартай уламжлалт төрлүүдийн нэг болжээ.



© Umumura Yutaka

хамаатай байх ч бий. Хүйсийн хэм хэмжээ нь СББӨ-ийг өвлүүлэн уламжлахад нөлөөлдөг бол СББӨ нь хүйсийн хэм хэмжээг тогтоон хадгалж хамгаалахад нөлөөлдөг. Тийм учраас СББӨ болон хүйсийн хэм хэмжээ нь зүй зохистой харилцаанд байдаг юм.

Хүйстэй холбогдолтой өөрчлөлтөд нөлөөлдөг өөр нэг хүчин зүйл нь хэлэлцэн тохиролцох явцад идэвхтэй оролцох, хэн нь нөлөөлж байгаа тухай асуудал юм. СББӨ-ийг хадгалан хамгаалах ба өвлөн уламжлах талаар шийдвэр гаргах үйл явц нь хоосон орон зайд бус харин хүйсийн болон эрх мэдлийн харилцааны томоохон системийн хүрээнд явагддаг. Тэрхүү хамт олны хэм хэмжээ болоод харилцаа нь хүмүүсийн зан төрх, үйлдэл, харилцаа хийгээд яриа хэлэлцлийн явцыг удирдан залж байдаг тэдгээр хэм хэмжээ, дэг ёс нь хамт олон дотроо олон дахин шүүн хэлэлцэгдэх бөгөөд энэ нь илүү хүн хамруулах болон эрх мэдлийн харилцааг тэнцвэржүүлэхийг зорьдог юм.


Циаттиста нь Киприйн яруу найргийн үгэн тулааны нэг хэлбэр бөгөөд нэг яруу найрагч-дуучин нь аман яруу найраг цээжээр уншин өрсөлдөгчөө ялан дийлэхийг хичээдэг. Циаттиста нь хурим найр, яармаг худалдаа болон бусад олон нийтийн баяр ёслолуудын нийтлэг нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсоор ирсэн агаад үзэгчид олон нийт яруу найрагчдын тоглолтыг урамшуулан дэмжиж байдаг. Уламжлал ёсоор зөвхөн эрчүүд л өөрсдийн яруу найргийг ингэж амаар өвлөн уламжилдаг байсан бол сүүлийн үед цөөн тооны эмэгтэй найрагчид тоглолт, үзүүлбэрт оролцож эхэлсэн байна.



© 2003 Larnaca Municipality - Photograph: Andreas Larkos



© 2003 Larnaca Municipality - Photograph: Andreas Larkos



© 2005 Department of Traditional Arts at the Research Center of ICHHO
Photograph: Said Azadi



© 2005 Department of Traditional Arts at the Research Center of ICHHO
Photograph: Nabollah Ghaychi

Хүйсийн тухай олон төрлийн үзэл баримтлал

СББӨ нь хамт олноос хамаарч олон янз байдгийн адилаар хүйсийн тухай үзэл баримтлал ч гэсэн олон янз байна. Хүйсийн талаарх дэлхий нийтийн нийтлэг ойлголт гэж байхгүй. Гэсэн хэдий ч хүйсийн үүрэг ба үнэт зүйлийг хамт олны хөгжлийн хэтийн төлвийн үүднээс задлан шинжлэх шаардлагатай. Тухайлбал Хойд Америкийн зарим уугуул овог аймгууд транс-жендэр болон давхар сүнстэй хүмүүс гэх зэргээр 7 хүртэлх бусад хүйсийг хүлээн зөвшөөрдөг.

Европын болон Азийн хэд хэдэн улс орнууд өнөөдөр 3 болон түүнээс дээш хүйсийн бүлгийг хүлээн зөвшөөрдөг. Ихэнхдээ хүмүүсийн нас хийгээд хүйс нь хоорондоо нарийн холбоотой. Тухайлбал, хүүхдийн зан төрх, үйлдлийн хүйсээс хамаарах хэм хэмжээ, хүлээлт нь өсвөр насныхан болоод насанд хүрэгчдийнхээс ялгаатай. Хүйсийн үүрэг болоод үнэт зүйлс нийгэмд хувьсан өөрчлөгдөхөд тэрхүү өөрчлөлтүүд нь ёс заншил, СББӨ-ийн илэрхийлэл болж тогтон төлөвшихөд хүргэж болно.

Ираны жүжгийн тоглолтын хамгийн эртний хэлбэр болох Наккалигийн тууль нь нийгмийн бүхий л шатанд маш чухал үүрэг гүйцэтгэдэг агаад түүнийг өвлөн уламжлахад хүйсийн үүрэг нь өөрчлөгдсөөр байна. Өдгөө эмэгтэй Наккалчууд холимог үзэгчдийн өмнө тоглож байгаа бөгөөд энэ нь Иранд ер бусын явдал юм. Учир нь эмэгтэйчүүд гол төлөв зөвхөн эмэгтэй үзэгчдэд зориулж тоглодог ёстой. Саяхныг хүртэл Наккалчуудыг ардын аман зохиол, үндэсний тууль хийгээд Ираны уламжлалт соёлын хамгийн гол хамгаалагч харуул гэж үзэж байсан бөгөөд энэ нь тэдэнд нийгмийн онцгой байр суурь олгож байв. Өдгөө харин эмэгтэйчүүд түүнд оролцох боломжтой болжээ.

Жендэрийн тэгш байдал

Хамт олноудын хүйсийн харилцаа цаг ямагт хувьсан өөрчлөгдсөнөөр хүйсийн тэгш байдал тогтож СББӨ-ийн илэрхийлэл, ёс заншлаар дамжуулан хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг даван туулахад чиглэсэн боломжуудыг бий болгодог. Тэгш эрх, үл ялгаварлах нь хүний эрхийн үндсэн зарчим юм. Хүний эрхийн үзэл санаа нь хүйсийн тэгш байдал ба СББӨ-ийг авч үзэхдээ зөвхөн хүйсийн үүргийн ялгааг бус харин хүйсийн үүрэг нь түүнд оролцогсдын нэр төр, сайн сайхан байдалд саад болж буй эсэхийг анхаарч авч үздэг.

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох тухай Конвенц (CEDAW) нь уламжлалт соёлын хандлага, ёс заншлуудыг өөрийг нь асуудал болгон авч үздэггүй бөгөөд (тэр ч бүү хэл эрчүүд болон эмэгтэйчүүдэд зориулсан ялгаатай үүргүүдийг) харин үеэ өнгөрөөсөн хэвшмэл (стереотип), эмэгтэйчүүдийн хүчин чармайлтыг бууруулж, сонирхлыг нь мохоосон ёс заншлуудаас сөрөг үр дагавар гарч байгаа эсэхэд анхаардаг.

Үл ялгаварлах үзэл санааны үүднээс авч үзвэл ялгаварлан гадуурхах болоод үг дуугүй захирагдах ёсыг багтаадаг, заримдаа бүр хөхиүлэн дэмжсэн уламжлалт соёлын зан заншлын зүйлүүдийг ‘хамгаалах’ гэж зүтгэхийг шүүн хэлэлцэж магадалж байх нь зөв юм. Үүнийг тэдгээр ёс заншлуудын улмаас шоовдорлогдон, эрх мэдэлгүй болсон хүмүүсийн эрхийг зөрчиж байна гэж үзэх нь зүйтэй. Тодорхой зарим ёс заншил нь хүний эрхийн үзэл санааны талаас авч үзвэл хэзээ ч хүлээн зөвшөөрөх боломжгүй нь ойлгомжтой байдаг бол харин хувь хүнд учруулах муу нөлөөг нь тодорхойлоход ярвигтай

завсрын бүдэг орон зайд байгаа өөр олон ёс заншлууд байсаар байна. Энэ нь хэн, хэзээ энэхүү хор холбогдлыг тодорхойлох вэ гэсэн бэрх асуултыг тавьж байна. Үл ялгаварлах зарчмыг баримтлан хамт олны сайн сайхны үүднээс энэ асуудлыг шийдэхэд холбогдох бүхий л оролцогчдыг, тухайлбал гадуурхагдсан юм уу хүйсээр ялгаварлагдсан бүлгүүдийг хамруулах шаардлагатай. Нөгөө талаас дээрх нийгмийн бүлгүүд өөрсдөө ялгаварлан гадуурхсан уламжлал, ёс заншлыг хөхиүлэн дэмжиж байж ч болно. Үүний шалтгаан нь гол төлөв ёс заншлын нийгмийн үүрэгтэй холбоотой бөгөөд нийгмийн амьдрал дахь хүйсийн өөрчлөлтийг ойлгох нь чухал ач холбогдолтой. Тэр ч бүү хэл хэрэв ёс заншлын зарим хэсэг нь хүний эрхийг зөрчиж байгаа ч тэр нь нийгмийн чухал үүрэг гүйцэтгэж байж болох талтай.



Маэндэлэо Я Ванамакэ нь эм бэлэг эрхтэнийг зориудаар зүсч тэмдэглэдэг насанд хүрсний зан үйлийг сахин дагадаг (FGM) хамт олонтой ажилладаг уламжлалт бус боловч орлох зан үйл үйлдэж хэвшүүлэх шилжилтийн үед нь хамт байлцаж, уламжлалт зан үйлийн нийгэм-соёлын эерэг талыг сахин хадгалахын төлөө ажилладаг Кенийн эмэгтэйчүүдийн байгууллага юм. Энэхүү эмэгтэйчүүдийн байгууллага нь эцэг, эх, тэдний охид болон хамт олны тэргүүлэгчидтэй уулзаж хамтдаа хэрхэн, яаж тийм уламжлалыг өөрчлөн шинэчлэх талаар санал солилцдог байна. Тэд нас бие гүйцсэний уламжлалт баяр ёслолын бүхий л хэсгүүдийг багтаах бөгөөд (гэр бүлээс гаргах, мэдээлэл солилцох ба баяр тэмдэглэх) харин эм бэлэг эрхтэнийг зүсч хөнддөг уламжлалт үйлдлийг нь орхисон шинэ, орлож болох зан үйлийг төлөвлөн хэвшүүлж байна. Энэ нь Нтанира На Мугамбо буюу 'үгээр зүсдэг хагалбар' хэмээн нэрлэгдэх болсон. Энэхүү уламжлалт бус орлох зан үйлийг анх Кенийн Меруд хийж эхлэхэд зөвхөн 12 айлын 30 гаруй охид тэрхүү насанд хүрсний баярт оролцож байсан. Хамт олон дунд ихэнх хүмүүс эргэлзэж, өөрчлөгдсөн уламжлал удахгүй замхран алга болно гэж бодож байв. Гэвч тэрхүү баяр ёслол хүмүүсийн анхаарлыг татаж дараагаар нь Маэндэлэо Я Ванамакэ урам зориг, санаачлагатай олон хувь хүн, хамт олон, бүлгүүдээс баярт оролцох хүсэлт авч эхэлжээ. Жилийн дотор Меругийн 11 газраас 200 гаруй гэр бүл энэхүү уламжлалт зан үйлийг орлох баяр ёслолд оролцсон байна.¹

СББӨ-ийн хүйсээр ялгаварлах зүйлүүд байгаа тухай ярихдаа ямар нэг хүйсийн бүлэг тухайн зан үйлийг даган мөрдөж байна гээд түүнээс шууд татгалзах гэсэн хэтэрхий гэнэн бодол санаа гаргахгүй байхыг сануулж болгоомжлуулахыг анхаарах шаардлагатай. Дэлхий даяар, ихэнх нийгэмд нийгмийн болоод соёлын ёс заншлууд нь хүйсийн үүргээр тус тусдаа (нас, хүйс болон бусад үзүүлэлтүүдэд үндэслэн) байдаг нь бодит үнэн юм. Гэхдээ дан ганц энэ шалтгаанаар ялгаварлан гадуурхах явдал байна гэж үзэх нь өрөөсгөл юм. Зөвхөн хүйсэд суурилсан судалгаа шинжилгээнд үндэслэн хамт олон нь тэдний СББӨ нь (нийгмийн ёс заншил, зан үйл,

ноу-хау, аман зохиол г.м) үнэхээр ялгаварлан гадуурхах явдлыг багтааж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой. Үүнээс гадна хүйсүүд салангид байх явдлыг ялгаварлан гадуурхдаг гэж тодорхойлогдох тийм үзүүлэлтэд оруулах шаардлагагүй.

СББӨ-ийг хадгалж хамгаалах тухай Конвенцид хүний эрхийг хамгаалах хүсэл зорилго тодорхой тусгагдсан бөгөөд энэ нь олон улсын хүний эрхийн жишигт нийцсэн СББӨ-ийг л Конвенцийн (2.1 дүгээр заалт) хүрээнд авч үзэж болохыг баталгаажуулж байна.

1. Маэндэлэо Я Ванамакэ байгууллага. 2002. Эм бэлэг эрхтэнийг гажуудуулах зан заншлыг зогсоох хүчин чармайлтыг үнэлэх нь. Кени дэх хор хөнөөлтэй хэм хэмжээг өөрчлөх ба ойлголтыг нэмэгдүүлэх нь, Вашингтон хот: PATH

Хадгалж хамгаалах үйл хэрэгт хүйсийн оролцоо

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцаа болон СББӨ хоорондын гүн гүнзгий харилцан хамаарлыг ойлгох нь түүнийг үр дүнтэй хадгалж хамгаалахад шинэ арга замыг нээж өгөх боломжтой. Хадгалж хамгаалахад хамт олны онцгой үүрэг оролцоог анхаарч хөгжүүлэх явдал бол энэ утгаар чухал нөөц бололцоо юм. Хамт олнууд, нийгмийн бүлгүүд нь нэг л төрлийн байдаггүй учир тухайн соёлын биет бус өвтэй холбоотой оролцогчдын олон төрөл, бас үүргийг тодорхойлох нь чухал бөгөөд ингэхдээ хүйсийн асуудалд ач холбогдол өгөх хэрэгтэй. Ингэхгүй бол үр дүнтэй хадгалж хамгаалахад учрах эрсдлийн шинэ боломжууд нь мэдэгдэхгүй байхын сацуу ашиглагдахгүй үлдэж болно.

Хүйс ба СББӨ нь олон талаар харилцан үйлчилдэг бөгөөд хууль тогтоомж, ёс заншил, өвлөн уламжлах зэргээр дамжин харилцан бие биедээ нөлөөлдөг. Тиймээс хадгалж хамгаалах арга хандлага нь хүйсийн харилцаанд үр нөлөө үзүүлэх боломжтойн зэрэгцээ, хамт олон, түүний гишүүд юм уу бусад салбар бүлгүүдийн статус болон нэр төрийг бэхжүүлэх бас сулруулах нөлөөтэй.

Конвенц нь үндэсний болон олон улсын түвшинд хадгалж хамгаалахад тодорхой арга хэмжээнүүдийг урьдчилан төлөвлөдөг. Үндэсний түвшинд тэдгээр арга хэмжээ нь СББӨ-ийг тодорхойлох ба бүртгэх, бодлогын болон эрх зүйн хамрах хүрээг тогтоох, хадгалж хамгаалах төлөвлөгөө, судалгаа хийх болон мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, боловсролын талаар идэвх санаачилгууд гаргах зэрэг нь үүнд багтана. Олон улсын түвшинд гишүүн орнууд нь хадгалж хамгаалахдаа олон улсын тусалцаа хүсэж

болохоос гадна Конвенцийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг өргөн барих юм уу ёс заншлыг хамгаалсан шилдэг туршлагын жагсаалтад санал болгох зэрэг болно.

СББӨ-ийг олж тогтооход хүйсийн оролцоо

Конвенцийг хэрэгжүүлэхэд тулгардаг нэг асуудал бол СББӨ-ийг (дахин) бүтээх болон хадгалж хамгаалахад оруулж буй эмэгтэйчүүдийн хувь нэмэр ил харагддаггүй явдал юм. Үүний нэгэн адилаар нийгмийн гадуурхагдсан бүлгийн гишүүдийн хувь нэмэр үндэсний болоод олон улсын түвшинд төдийлөн танигддаггүй.² Заримдаа гадуурхагдсан хүйсийн бүлгийн гишүүдийн СББӨ-ийн хэвшин тогтсон орон зай нь нийгмээс тэдэнд үйл ажиллагаа явуулах боломж олгож буй цорын ганц орон зай байх нь бий. Тийм учраас үндэсний түвшинд СББӨ-ийг олж тогтооход хүйсийн ялгаварлан гадуурхах явдал эрсдлийг дагуулдаг бөгөөд тодорхой хүйсийн бүлгийн өвийг үгүйсгэдэг тал бий.

“Ванигийн Эмэгтэйчүүдийн Түүх төсөл нь Австралийн уугуул эмэгтэйчүүд санаачлан, удирдан зохион байгуулсан, аман түүхийн төсөл юм. Энэ төсөл нь хамаарал бүхий өвийг олж тогтоох, мөн өвийг тодорхойлох, удирдан зохицуулах менежментийн үйл ажиллагаан дахь хүйсийн болон бусад алагчлах асуудлыг ишидвэрлэхэд гол анхаарлаа хандуулж ирсэн байна. Дээрх эмэгтэйчүүд Засгийн газрын төлөвлөгөөнд өвийнхөө талаар санаа зовоосон асуудлуудад зохих ёсны анхаарал хандуулахгүй байгаа бөгөөд эрх зүйн хувьд баталгаажуулаагүй байна хэмээн үзэж байна. Тэд өөрсдийн өвийн ирээдүйн талаарх хэлэлцээрт дуу хоолойгоо хүргэх стратегийг боловсруулж, өөрсдийгөө таниулан зөвшөөрүүлж чадсан байна.”³

2. ITN баримт бичиг/13/8COM/INF.5c.

3. Смит, Л., Морган, А. ба Ван Дэр Мээр, А. 2003. Соёлын өвийн менежмент дэх хамт олонд түшиглэсэн судалгаа: Вааний Эмэгтэйчүүдийн түүхэн төсөл. Өв судлалын олон улсын сэтгүүл, 9 дүгээр дэвтэр, No.1.



© UNESCO – Photograph: Fumiko Ohinata

Бүртгэх ажилд хүйсийн оролцоо

СББӨ-ийг тодорхойлоход тулгардаг асуудалтай нэгэн адил СББӨ-ийн бүртгэлийн ажил болон холбогдох судалгаа, баримтжуулалт нь СББӨ-д эмэгтэйчүүд хийгээд гадуурхагдсан бүлгийн оруулсан хувь нэмрийг дурдахгүй өнгөрөх, эсвэл танилцуулахгүй орхих эрсдлийг дагуулсаар байна. Конвенцийн дагуу СББӨ-ийн бүртгэлийн ажил нь холбогдох хамт олны бүгдийнх нь оролцоотойгоор хийгдэх ёстой. Тийм учраас хамт олонд түшиглэсэн бүртгэлийн ажлын туслалцаа болон сургалт нь хүйсийн хувьд хамт олны бүрэн оролцоог хангасан эсэхийг авч үзэж байх шаардлагатай. Энэхүү үйл явцаар дамжин СББӨ-ийн маш олон зүйлийг тодорхойлж болох бөгөөд хадгалж хамгаалах асуудлыг хөндсөн, хүйсэд суурилсан төсөөлөл ойлголтуудыг тодоор харах боломжтой.

Хадгалж хамгаалах төлөвлөгөөнд хүйсийн оролцоо

СББӨ-ийг хадгалж хамгаалах төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах нь тухайн СББӨ-ийн цаашдын хувь заяанд нь нөлөөлөх шийдвэрлэх цаг юм. Хамт олон нь тодорхой ёс заншлын ач холбогдол болон утга учир, холбогдох эрсдэл ба аюул, тэдгээрт чиглэсэн стратеги, үйл ажиллагаа болон хүмүүнлэгийн, санхүүгийн эх үүсвэрүүдийг өөртөө байнга тусгаж анхаарч байдаг билээ. Энэхүү үйл явц нь хамт олны бүх л гишүүдэд хүртээмжтэй байхын тулд ондоо нас болон хүйсийн бүлгүүдийн дуу хоолойг анхаарч үзэх шаардлагатай. Нэн тэргүүнд хамт олон нь хүйс ба хүйсийн үүргийн талаарх өөрсдийн ойлголт хийгээд тэдгээр нь өвтэй хэрхэн холбогддог болохыг тодорхой илэрхийлэх хэрэгтэй. Засгийн газрын удирдлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний

хүрээлэнгүүд болон судалгааны хамт олон нь өөрсдийн хэтийн төлөв хийгээд арга зүйн мэдлэгээрээ хадгалж хамгаалахад хүйсийн хэтийн төлвийг хэрхэн нэгтгэх тал дээр хувь нэмрээ оруулах боломжтой. Энд хамгийн чухал зүйл гэвэл төлөвлөгөө боловсруулахад хамт олон оролцож, түүнийг талархан дэмжих явдал бөгөөд энэ нь хадгалж хамгаалах төлөвлөгөөнд тэдний зүгээс оруулж буй хувь нэмэр болно.

Бодлого боловсруулахад хүйсийн оролцоо

Хэрэв СББӨ-ийн бодлогууд нь хүйс ба СББӨ хоорондын тааламжтай харилцаа бий болгох гэж буй бол хадгалж хамгаалах бодлого боловсруулах нь холбогдох бүх хүйсийн бүлгүүдийн олон талын дуу хоолойны идэвхтэй оролцоог хангасан байх шаардлагатай. Бодлого боловсруулах ажлыг хамт олны цөөн тооны гишүүд, гадны мэргэжилтнүүд юм уу төрийн байгууллагуудад даатгах нь эрсдэлтэй. Бодлого боловсруулах нь хүний эрхийн зарчмууд (хүйсийн тэгш байдал үүнд багтана), тогтвортой хөгжил болон Конвенцийн хүрээнд СББӨ-ийг (2.1 зүйл) хадгалж хамгаалахад харилцан хүндлэлийг бэхжүүлэх арга замуудыг хөхиүлэн дэмжиж, түүнчлэн СББӨ-ийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд нь ‘улс төр, нийгэм, үндэстэн, шашин, хэл эсхүл хүйсэд тулгуурласан аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхах явдлыг зөвтгөх’-өд (Үйл ажиллагааны удирдамж 102) хувь нэмрээ оруулахгүй байхыг баталгаажуулах ёстой. CEDAW ба түүний нэмэлт протокол⁴ зэрэг хүйсийн тэгш байдалтай холбоотой олон улсын хэлэлцээр нь ашиг тустай зөвлөмж



© 2012, agency for Cultural Affairs



© 2012 by Firoz Mahmud - Photograph: Murshid Anwar

байж болно. Мөн түүнчлэн бодлогын үйл ажиллагаа нь олныг хамарсан, үр дүнтэй байхын тулд тухайн улсын нутаг дэвсгэр дэх хүйстэй хамааралтай олон төрөл ёс заншлуудыг авч үзэх шаардлагатай.

4. Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенц ба түүний нэмэлт Протокол, <http://www.ohchr.org/en/hrbodies/cedaw/pages/cedawindex.aspx>

Олон улсын бүртгэлд оруулахад хүйсийн оролцоо

Сүүлийн 10 гаруй жилийн туршид хүйсийн тухай асуудлуудыг СББӨ-ийг бүртгэх талаарх Засгийн Газар хоорондын хорооны хэлэлцүүлэг шийдвэрүүдэд улам ихээр дурдах болсон. Хэдийгээр хүйсийн үүргийг зарим нэг нэр дэвшиж буй баримт бичгүүдэд багтаах болсон авч Зөвлөх байгууллагууд нэр дэвшүүлж буй баримт бичгүүдэд хүйсийн асуудал хангалттай дурдагдахгүй байгаад санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Цаашлаад Зөвлөх байгууллагууд нь Гишүүн орнуудаас хүйсийн асуудалд анхаарлаа хандуулж нэр дэвшүүлэх баримт бичигт СББӨ-тэй холбоотой олон талын оролцогчид болон тэдний үүргийн талаар тодорхой тайлбар хийж байхыг хөхиүлэн дэмжсэн.⁵

Хүйсийг нийгмийн бодлого болгохуй

Хэдийгээр Конвенц нь хүйсийн тухай тодорхой дурдаагүй боловч удирдах байгууллагууд нь хүйсийн асуудалд хандуулах анхаарлаа улам бүр нэмэгдүүлэхийн сацуу Гишүүн орнууд бүртгэгдсэн өвийн зүйлүүдийн байдлын талаар тайлагнахдаа ‘хүйсийн үүрэг оролцоонд илүү ихээр анхаарлаа хандуулах’-ыг хүсэх болсон.⁶ Тэрхүү хүсэлтийн дагуу олон улсын хамтын ажиллагааны механизмуудтай холбоотой бүхий л хэлбэр хийгээд удирдамж, мөн түүнчлэн Конвенцийг хэрэгжүүлэх Гишүүн орнуудын хугацаат тайлангууд нь өдгөө хүйстэй хамааралтай зөвлөмжүүдийг тусгасны сацуу тэдгэртэй уялдан Конвенцийн Үйл Ажиллагааны Удирдамж

нь мөн өөрчлөгдөн сайжирсан. Үүнээс гадна ЮНЕСКО-гийн Конвенцийн хэрэгжилтийн чадавхийг дээшлүүлэх дэлхийн хөтөлбөр нь сургалт болон бодлогодоо хүйсийн асуудалд чиглэсэн хандлага баримталж ажиллахыг зөвлөдөг.

Хүйс болон СББӨ-ийн харилцааг ойлгох нь үр дүнтэй хадгалж хамгаалахад хоёр утгаар ач холбогдолтой: энэ нь хадгалж хамгаалах шинэ арга замыг нээгээд зогсохгүй хүйсийн тэгш эрхийг хангахад дэмжлэг үзүүлнэ. Тиймээс хадгалж хамгаалах ажилд хүйсийг анхаарч гол чиглэл болгох нь зөвхөн бололцоо төдий бус харин ёс зүйн үүрэг хариуцлага юм.

Эмэгтэйчүүдийн Үндэсний Зөвлөл нь Египетийн Ардын Уламжлалын Холбоо (ESFT) ТББ-аас Таллыгийн урлагийг баримтжуулах, түүнийг хадгалан хамгаалахад туслах, Дээд Египетийн эмэгтэйчүүдэд хэрхэн өвөө хамгаалах талаар сургалт явуулахыг хүссэн юм. 300 гаруй эмэгтэйчүүд анхны сургалтын хөтөлбөрт хамрагдсан агаад дараа нь хоёр дахийг нь зохион байгуулсан байна. Дасгал хичээлүүдийг эмэгтэйчүүд ихээр сонирхсон нь тэдний хувьд чухалд тооцогддог боловч ихээхэн аюул заналд өртөөд буй тэрхүү онцгой СББӨ-ийг дахин сэргээхэд хүргэсэн байна.



5. ITN баримт/13/8COM/7.

6. Шийдвэр 9.COM ITN баримтын 13.а/14/9COM/Шийдвэрүүд.





Соёлын биет бус өв



The designations employed and the presentation of material throughout this publication do not imply the expression of any opinion whatsoever on the part of UNESCO concerning the legal status of any country, territory, city or area or of its authorities, or the delimitation of its frontiers or boundaries. The authors are responsible for the choice and the presentation of the facts contained in this book and for the opinions expressed therein, which are not necessarily those of UNESCO and do not commit the Organization.

The present translation has been prepared under the responsibility of the International Information and Networking Centre for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region under the auspices of UNESCO (ICHCAP) and Mongolian National Commission for UNESCO.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

ichcap

International Information and Networking Centre
for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region
under the auspices of UNESCO



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Mongolian
National Commission
for UNESCO